

ЯПОНЫ ХӨГЖЛИЙН ТУРШЛАГА

Н. Дангаасүрэн

Япон орон дэлхийн хөгжлийн нэгэн «гайхамшиг» болтол хөгжихөд ердөө зуун жилийн хөдөлмөр орсон гэхэд үнэхээр итгэхэд хэцүү. Техникийн эриний хагас мянганы туршлагатай өрнөдийнхэн болон хос зууны глалзсан замыг туулсан америкчууд хүртэл энэхүү гэнэт санамсаргүй тодорсон «хэт их гүрнийг» хачирхах төдийгүй хүндэтгэх болсон юм. Их далай бүслүүртэй цуваа арлын энэ орныхон өнгөрсөн зууны сүүлч хүртэл хэний ч анхаарал татдаггүй «мартагдсан зэлүүд нутаг» мэт байлаа. Азийн эх нутгийнхантай угсаа гарал, соёлын нягт холбоотой байсан япончуудын түүх нь хүртэл их цагийн эрхээр элэгдэн мартагдсан бололтой. Эх газрын Монголтой тэдний холбоо сүлбээ бүдгэрч, харин Хятад, Солонгос зэрэг зэргэлдээ улс түмэнтэй харилцаа тасарсангүй. Япончууд уламжлалт нийгмээс аж үйлдвэржсэн нийгэмд шилжих үүдээ өнгөрсөн зууны жараад оны сүүлчээр нээжээ.

Дундад зууныхаа төвшингөөс гараагүй Япон орныхон, Америк, Европын өндөр хөгжилтэй улс гүрний уурын хөдөлгүүрт хөлөг онгоцнуудад хаалгаа нээхдээ «дотроо бололтой, дороо суурьтай» ухаалаг бөгөөд зоригтой алхам хийсэн нь эзэн хаан Мэйзи, түүний хамтран зүтгэгчдийн алсын хараатай бодлого мөнгийг түүх нэгэнт баталжээ. Японы нэрт дипломат Исийн «Дипломат» гэдэг зохиолд «наран мандахаас,

Н. Дангаасүрэн —Зүүн хойт Ази судлалын төвийн тэргүүлэх ажилтан, түүхийн ухааны доктор.

наран шингэх хүртлэх манай аугаа их гүрэн» гэсэн монголын их гүрний төрийн дууллын нэгэн бадаг сонирхол татаад зогсоогүй Япон бол бусдын хараанд ороогүй цойлсон Азийн бараг ганц орны хувьд гайхагддаг.

АНУ, Голланд, Англи, Франц, Германыг оролцуулан маш өндөр хөгжсөн орны техник шинжлэх ухааны чадварыг хоцрогдсон Япон орон өөртөө үр өгөөжтэй ашигласан Азийн ганц «сэргэлэн» улс юм. Токио хотын дүүргүүд 1945 онд үндсэн товрог болтлоо бөмбөгдүүлж, Хиросимд дэлхийн анхны цөмийн дэлбэрэлт болсны дараахны Японыг харсан хэнд боловч «ойрын ирээдүйн дэлхийн хоёрдахь баян, хүчирхэг гүрэн» гэсэн бодол санаанд нь ургахгүй байсан биз. Энд Япон орны хөгжлийн хоёрдахь «гайхамшиг» бий. Юу ч атугай Японы 1868 оны «нээлттэй хаалгын» бодлого нь өнөөгийн монголын хөгжлийн үйл явцтай олон зүйлээр төстэй мэт. «Нээлттэй хаалга» гэдэг бол харьцангуй ойлголт юм. Энэ бол хил хязгаараа дэлгээд, нүдээ аньж азаа сорихын эсрэг үйлс гэдгийг дурьдахад илүүдэхгүй. «Нээлттэй хаалга» хэнд, юунд нээлттэй, хэнд юунд хаалттай байлгахыг эрс зааглан салгадагт хамаг учир бий. Япончууд дэлхийн хамгийн өндөр хөгжсөн тодорхой техник, технологи, оюуны хамгийн өндөр түвшинд хүрсэн ололтонд үүд хаалгаа нээсэн юм. «Хамгийн өндөр түвшинд хүрсэн» гэдэгт хамаг учир бий. «Нээлттэй хаалга» бол Японы эзэн хаант төрийн хурц соргог хяналтанд тодорхой зүйлд, тодорхой болзолтой, нарийн тооцоотой хийсэн алхмууд байлаа.

Азийн олонхи орон, өрнөдийн аль нэг гүрний эрхшээлд автаж байхад япончууд тэгсэнгүй, Чухамдаа тэд Америк, Европын зөвхөн өндөр хөгжилтэй улс гүрнүүдэд үүд хаалгаа «нэгэн зэрэг» нээсэн байна. Ингэхлээ японы эзэн хаант төрийн зүгээс тэдгээр хөгжилтэй гүрэн тус бүрт адил болзлоор төстэй техник, технологи оруулах тохиролцооны арга замаар тэдний хооронд нь уралдуулсан ажээ. Япон орон ингэж өрнөдийн техник, технологи, оюуны шинэ бүтээлийн уралдааны өвөрмөц «талбар» болжээ. Япон улс тэдгээр илүү хөгжилтэй улс гүрний өрсөлдөөн дундаас зөвхөн хожжээ. Ш. Лувсанвандан профессор, японы дипломатын зохиолоос олж мэдсэнээ ярихад миний сэтгэл тун их хөдөлж билээ. Ш. Лувсанвандан профессор энэ зохиолыг ямар хэлээр уншсаныг лавлаагүй. Би өнөө болтол энэ зохиолыг олж үзэж чадаагүй явна. Монголчуудын хувьд «холгүй ойрхон, илгүй цалд» байсан энэ орныг бодитой танин мэдэх боломж нээгдэж магадгүй юм. Харин хорьдугаар зууны хувьд монголчууд бид л Азийн эх газрын «мартагдсан зэлүүд нутгийнхан» болсон байлаа. Энэ өнгөрсөн олон арван жилийн хугацаанд Япон улсыг өөрийн нүдээр харсан монголчууд бараг үгүй юм.

Монголчууд япон орныг зөвхөн хоёр хөршийн мэдээлдээс унших, сонсох төдий байсан. Монгол үндэстэн хагас мянган жилийн турш гаднын хагалан задлах, хуваан эзлэх «мэх-мэсийн бодлогод автаж» таслагдан хуваагдаад монголынхоо ядаж гал голомтыг атугай ч улс хэвээр хадгалахыг хичээсэн он жилүүдэд монголчууд «нээлттэй» бодлого явуулахыг оролдсон боловч Япон шинг үнчэсний бат нэгчлэл, үндэсний эрх дархаа хамгаалсан хүчтэй захиргаа дутагдаж байснаас «нэг ноёрхогчийн гараас, нөгөө ноёрхогчийн гар дамжин», тэдний «зориуд хоцрогдуулан», «үүрд араасаа дагуулах» эрчнээс эрин дамжсан бодлогод өнөөдөр хүртлээ дийлдсээр иржээ. Ийм нөхцөлд боловч монгол үндэстнийхээ хувь заяаны ариун үйлст амьдралаа зориулсан ухаантан зоригтнууд эрин бүрд төрж, тэмцлийн тавалгаа хүчээ авсаар ирлээ. Сэргэн мандалтын эрхэм дээд үзэл санаа өвөрлөсөн мон-

гол хүн бүр АНУ, Японы хөгжлийн үйл явцад хэзээний анхаарал тавьж байсныг үүнтэй зүй ёсоор холбон бодох учиртай.

Тусгаар тогтнож мандан өөдлөхийг эрмэлзэж байгаа монголчуудад хөрш «хэт их» хоёр гүрнээс гадна АНУ, Япон, дэлхийн бусад улс гүрний найдвартай дэмжлэг шаардлагатай гэдгийг түүхэн сургамжаас бид мэдэж авсан юм. Хичнээн олон улс гүрэнтэй нягт хамтран ажиллавал, төчнөөн хэмжээгээр монголын тусгаар тогтнол баталгаатай болно» гэсэн баримтлал өнөө онцгой ач холбогдолтой боллоо. Японы зуун жилийн ололт бол монголын хөгжлийн загварыг монголчууд өөрсдөө сэдэж бүтээхэд оюуны төдийгүй эдийн засгийн чухал хөшүүрэг болно. Монголчууд дэлхийн хамгийн өндөр түвшинд байгаа техник, технологи, шинжлэх ухааны мэдлэгийг шууд эзэмшихээс гараагаа эхлэх шаардлагатай болоод байна. Сүүлийн далан жилд «социалист» хүрээлэлд хашигдан хоцрогдсон техник, мэдлэг тэндээс оруулан «бэлэнчлэх үзэл» буюу эдийн засаг, оюуны жинхэнэ хараат дэг журамд орсон нь монголыг дэлхийн хөгжингүй хэсгээс улам холдуулжээ.

Монголчууд хүрэл төмөр урлалын уламжлалт ололтоо ахиулсаар 1077 онд их буу хүртэл үйлдсэн эрчимээ алдаагүй бол өнөө ямар түвшинд хүрэхийг барагцаалахад хэцүү. Мал аж ахуйн сонгомол уламжлалтай байсан монгол хүмүүс 1977 он гэхэд энэ салбарт гаднын хүчин, гаднын мэдлэгт шүтсэн орон болсон байлаа. Монголын дүрслэх урлаг, уран барилга, зурхай бусад монгол бүхэн мартагдлаа. Хамгийн орчин цагийн ололтыг монголчууд эзэмшсэн учраас «урьдах нь ул болсон» хэрэг үү гэхээр тийм ололтонд ойртох байтугай холджээ. Алив улс орон өөрийгөө дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй буюу түүнд эрмүүн хурднаар ойртож яваа оронтой зүйрлэн ололт доголдолдоо олж хардаг. Ирээдүйн монголын байр суурийг тэр цагийн хоцрогдсон улс дунд биш, харин хамгийн хөгжилтэй, баян улс гүрний дундаас олж харахыг хүссэн хэн бүхэн үүнийг бодууштай. Хэрэв ийм ажиглалт, судалгаа өнөө хийхгүй бол ирээдүйгээ оновчтой төсөөлж чадахгүйд хүрнэ. Японы хөгжлийн зуун жилийн үйл явц энэ утгаар монголчууд бидэнд онцгой үнэ цэнэтэй юм. Зүг бүхэнд бидний анхаарлыг татсан жижиг, дунд, том орнууд бий. Тэдний хөгжлийн «нууц» буюу тэдэнд бидний суралцвал зохих нандин мэдлэг туршлага бий. Тэдэнд монголчуудаас сонирхож мэдэх зүйл байж таарна. Энэ бүхнийг нээж чадвал хоёр болон олон талын хамтын ажиллагааны үндэс тавигдана гэж бодож байна. Энэ гарааны эхлэл нь Япон үндэстний хөгжлийн жишээг тал бүрээс ажиглах, судлах, өөрийн орны нөхцөлтэй уялдуулан харьцуулж эрэгцүүлэх явдал байх болов уу.

Монголын ирээдүйн хөгжлийн загвар монголын бодит байдлаас ухамсартай буюу аяндаа төрөх явцаар хөгжихдөө гаднын нөлөө, сургамж, жишээний ач холбогдлыг өндөр үнэлэхгүй байж болохгүй. Нарны элч, салхины урсгал, усны нөөцийн адил цаг хугацааг зөв ашигласан нь Японы зуун жилийн хөгжлийн нэгэн «гайхамшиг» байсныг энд онцлон дурьдахыг хүсч байна. Япончууд гадаадын техник, мэдлэгийг авахдаа, хамгийн сүүлчийн ололтыг соргог тусган бэлэн мэдлэгийг шилж аваад, түүнийг өөрсдөө хийх үйлэт цаг алдалгүй ордог байжээ. Ингээд дууриан хийхэд тун бага хугацаа хэрэглэн, түүнийг сайжруулахаас эхлэн хамаагүй илүүтэйг зохион бүтээхэд бүх анхаарлаа хандуулдаг байна.

Дэлхийн зах зээл дээр өрсөллөх чадварыг бий болгоход оюуны болон үйлдвэрлэлийн багаж хэрэгслийн үргэлжийн шинэчлэлт, улам илүүтэйг бүтээх эрэл хайгуулыг зогсолтгүй өрнүүлсэн асар өндөр тэв-

чээрт хөдөлмөр бол энэ орны хөгжлийн «нууц» юм. Энэ санааг би японы нэрт эрдэмтэн-эдийн засагч Сабуро Окита¹, Такафуса Накамура² нарын бүтээлээс уншиж байхад олсон билээ.

Эрин зууны хугацааг оновчтой зөв ашиглавал хүн ам, нутаг дэвсгэр, баялагийн нөөцийг харгалзахгүй, юуны урьд оюун ухааны нөөцдөө түшиглэн бусад баялагийн гачигдлаа нөхөөд, дэлхийн элбэг баян амьдралтай орон болдгийг япончууд бидэнд үзүүллээ. «Эрдмийг дээд баян» гэж өвөг дээдэс маань юутай мэргэн сургасныг энд санахад илүүдэхгүй. Өөрсдөө эрдмийг хичээхгүй бол бусад баялаг маань хүртэл бусдын халаасанд ордогийг бид нэгэнт ойлгосон. Монгол орныг Япон мэт өндөр хөгжилтэй болгох үйлсээ хэзээ юунаас эхлэхээ хүртэл бодохыг оройтуулж болохгүй. Энэ бүхнийг «өөрийгөө засахаас» эхэл гэж өвөг дээдэс маань бас захижээ. Монгол хүн бүхэн өөрийн адил ажил мэргэжилтэй Япон бол өрнөдийн бусад орны иргэдийн мэргэжил, мэдлэг, зүтгэлийн түвшинд хүрэх хэрэгтэй боллоо. Хэрэв үүнийг ахар хугацаанд амжуулвал цааш нь тэдэнтэй мэдлэг, чадвар, шинийг бүтээхийн уралдаанд орох ээлж тулгарна. Хүмүүсийн амьдрал, олон орны амьдрал алин боловч аз жаргалыг хөдөлмөрөөр олох «уралдаан» юм. Японы хөгжлийн түүхийг төсөөлөх дутам над ийм сэтгэлэг төрлөө.

Япон хүний сэтгэлийн тэнхээ, уйгагүй хөдөлмөр, даруу зан, нягт нямбай амьдрал, эвсэг хамтач зуршил зэрэг дорно дахины уламжлалт ёс суртахуунтай холбоотой онцлоггүйгээр «японы хөгжлийн загварыг» төсөөлөх аргагүй санагдана. Сакура цэцэгийн анхилам үнэр хүртэл эндээс мэдрэгдэнэ. Гадаадын шинжлэх ухаан-техникийн нээлттэй холбогдуулан Япон хүний баримталдаг нэг зүйл миний анхаарлыг татсан юм. Сабуро Окита профессор үүнтэй холбогдуулан хятадын эртний нэгэн зүйр үгийг иш татжээ. «Та хүнд загас өгвөл, тэр нэг удаа иднэ. Та түүнд загас барихыг сургавал, тэр дуртай цагтаа түүгээр хооллоно». Хятадын эртний яруу хэллэгтэй, гүн утгатай энэ цэцэн үгсийн англи орчуулгаас зөвхөн бүдүүвч утгыг энд тоймлосон учир уншигчдаас уучлал гуйна. Япончууд өөрсдөө энэ цэцэн үгтэй адил санаа сэтгэлтэй, түүнээ амьдралдаа тууштай баримталдагаас хятадын зүйр энэ үгийг мартдаггүй бололтой. Японы хөгжил бол чухамдаа хүн төрөлхтний хийж чаддаг бүхнийг япончууд хийж чадна гэсэн чин эрмэлзлэлийн үр шим ажээ. Энэ зорилгодоо хүрснээр япончууд тайвширсангүй, хүн төрөлхтний танин мэдээгүй тийш жолоогоо зоригтой залсанд тэдний «гайхамшиг» орших билээ. Урьдчилан төсөөлөх бололцоогүй тийш эрэл судалгааны жолоог залж хөрөнгө хүчээ хайрлахгүй зориулсан үндэстэн, ирэх эршний ухаантан, зоригтны манлай болох тавилантайд эргэлзэх юун. Эргэцүүлэн тунгаах зүйл монголчууд бидэнд тун их байна. Ингэж эргэцүүлэхэд япончуудын бүтээж босгосон хөгжил, тэдний оюуны баялаг их тус болно.

Монголчууд өнгөрсөн далан жилд мал, түүхий эд, байгалийн баялагаа шавхаж байгаад гадаадаас үлэмжхэн үйлдвэр, техник төхөөрөмж, авчирч ашиглажээ. Гэтэл энэ бүхэн элэгдэж хуучран сэлбэгээр гачигдан зогсож байна. Өнөө дахин аанай «бэлэнийг» авчирах эрэлд морно эмээллэн зүг зүг давхилдаж байна. Үүнээс үзэхэд монголын өнгөрсөн далан жилийн сургамж бол японы хөгжсөн замын урвуу тал гэлтэй. Хоригдол оросууд, олзны япончууд, тусламжийн орос, хятад ажилчид, урилгын мэргэжилтнээр монголчууд бид өөрсдийгөө орлуулж «хөгжлийг» хуурамчаар түрслэх биш, монгол хүн бүр мэдлэг чадвар, нөөц боломжоо дайчлахад хамаг учир оршдогийг японы ард түмний туршлага бидэнд нотолж байна.



Монголчууд хэрэв «нээлттэй хаалга» гэдгийг эндүү ойлгож хямд буюу өндөр хөлстэй гадаадын ажиллах хүчийг хяналтгүй оруулах, байгалийн баялагаа тэдэнд тавьж өгөх, гадаадын бэлэн үйлдвэр, багаж төхөөрөмжийг хяналтгүй оруулвал эцэстээ хоцрогдохоор барахгүй, ер нь монгол улс оршин тогтнохгүйд хүрэх аюул бодитой оршиж байгааг бодох цаг болжээ. Ийм гунигт байдалд хүрэхгүй байж, хорин нэгдүгээр зууныг монголын сэргэн мандалтын эрин болгоход Японы жишээ монголчууд бидэнд их ач холбогдолтой. Гэхдээ нөгөө тийш хэтрүүлж дадсан бидэнд болгоомжлох зүйл цөөнгүй. Нэг үе монголчууд бид «зөвлөлтийн туршлага» гэгчийг хуулахын хэнээрхэлд автснаар үлэмж алдсан. Өнөө «японы туршлага» гээд урьдын адил «хуулахыг» оролдвол хоёрдох алдаа болно. Үүнтэй холбогдуулан японы хөгжлийн бас нэгэн «гайхамшиг» нь япончууд өрнөдийн ололтыг чадмаг ашигласнаас бнш, түүнийг хуулаагүйг тэмдэглүүштэй.

Япончууд орчин үеийн технологи хөгжүүлэхдээ, үйлдвэрлэлийн уламжлалт арга туршлагатай нягт холбожээ. Хөдөөгийн хувийн жижиг аж ахуйгаас эхлэн, өрхийн жижиг үйлдвэр, бусад дунд жижиг үйлдвэрийн уламжлалыг хамгийн сүүлчийн техник, технологийн ололттой холбожээ. Том үйлдвэр, концернд ажиллагсад, боловсрол, судалгаа, үйлчилгээний зэрэг бүх салбарт япон үндэстний бүтээлч сэтгэлэг, ёс суртахууны шилдэг уламжлал хосолжээ. Хүн төрөлхтөний соёл иргэншлийг япончууд өвөрмөц давтагдашгүй хувь нэмрээр баяжуулжээ. Япончууд «хөгжлийн японы загварыг» бий болгожээ. Япон бол тэндээ нэг л «ертөнц» юм. «Харилцан хараат» байдлын хамгийн үр ашигтай хувилбарын нэг нь японы эдийн засгийн гадаад харилцаа ч байж мэднэ. Японы хөгжлийн амжилт бүхний нөгөө талд бэрхшээл доголдол байгаа нь мэдээж. Эрдэс болон байгалийн бусад баялгаар япончууд үргэлж дутагдаж байна. Ингэх тусмаа байгалийн жирийн нөөц болгоныг авхаалжтай ашиглахыг чармайж байна. Бас нэгэн эгзэгтэй зүйл нь гадаад зах зээлийн хэлбэлзэл юм. Энэ бүхнийг даван урагшлах уян хатан үйл ажиллагааг явуулж чаддагт тэдний хүч байна. Японы хөгжлийн ундраа нь япончуудын өөрсдийн соргог ухаан уйгагүй хөдөлмөр ажээ. Японы хөгжлийн жишээг тоймлосны эцэст: монголчууд бидэнд бэлэн үйлчлэх «ид шидийг» тэндээс олсонгүй. Харин өөрийн хүчийг дайчлах цорын ганц мэргэн зам байдгийг улам бүр мэдэрлээ. Профессор Такафуса Накамура бүтээлдээ дайны дараах японы эдийн засгийн бүтэц, өсөлтийн үйл явцыг шинжилсэн байна. Сабуро Окита, Такафуса Накамура нарын зохиолд Японы эдийн засаг, санхүү, техникийн хөгжлийн үйл явцад тохиолдсон бэрхшээл, элдэв хэлбэлзэл, бүтэлгүйдэлтийг туулж давсан хатуу ширүүн сорилтыг нарийвчлан харуулжээ. Энэ мэт бүтээл маш олныг японы эрдэмтэд туурвижээ. Японы эрдэмтдийн бүтээлтэй монголын өргөн олон уншигчид шүүд танилцах боломжийг даруй нээгээсэй гэсэн бодол над өөрийн эрхгүй төрлөө. Ингэснээр монголчуудын бүтээлч үйлсийн сэргэн мандахад асар их дэмжлэг болохсон билээ. Японы хөгжлийн жишээнээс сурах юм их байна.

1. Saburo Okita. The Developing Economies and Japan. Tokyo. 1986.
2. Takafusa Nakamura. The Postwar Japanese Economy. Tokyo. 1988.